

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ТАНИЛЦУУЛСАН ХУУДАС

Огноо: 2025.06.11

Танилцуулсан шийдвэр:

1. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны " Эрх шилжүүлэх тухай" 393 дугаар тогтоол
2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны " Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай" 109 дүгээр тогтоол
- 3.Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай" А/630 дугаар захирамж

№	Ажлын байр	Нэр	Танилцсан эсэх	Гарын үсэг
1	2	3	4	5
Захиргаа удирдлагын хэлтэс				
1	Ахлах мэргэжилтэн	Т.Оюунтуул	Танилцсан	
2		Ж.Сувданзаяа	Танилцсан	
3		Г.Даваамөнх	Танилцсан	
4	Мэргэжилтэн	Ж.Үүрийнтуяа	танилцсан	
5		А.Номундалай	Танилцсан	
6		М.Урангоо	танилцсан	
7		М.Энхбаяр	Танилцсан	
8	Хөрөнгийн ашиглалт, хөдөлгөөн хариуцсан ажилтан	Т.Алтангэрэл	Танилцсан	
9		О.Төмөр	Танилцсан	
10		З.Оргилболд	Танилцсан	
11	Ерөнхий нягтлан бодогч	Г.Саранчимэг	Танилцсан	
12	Нягтлан бодогч	Ц.Даваажав	Танилцсан	
13	Программистт сүлжээний	Г.Очбаяр	Танилцсан	
14	Нярав	Д.Батбаяр	Танилцсан	
15	Архивын ажилтан	Ц.Болормаа	Танилцсан	
16	Жолооч	С.Өлзийбаяр	Танилцсан	
17		Ц.Баясгалан	Танилцсан	
18	Үйлчлэгч	Б.Гал-Эрдэнэ	Танилцсан	
19		М.Наранзул	танилцсан	
Хууль зүйн хэлтэс				

20	Хэлтсийн дарга	Б.Баясалмаа ✓	Тамиржав	Агваа
21		Б.Нандин-Эрдэнэ ✓	Тамиржав	Агваа
Өмчийн хяналт шалгалтын хэлтэс				
22	Мэргэжилтэн	Г.Тэмүүжин ✓	Тамиржав	Агваа
23		Б.Адьяа ✓	Тамиржав	Агваа
24		О.Уранчимэг ✓	Тамиржав	Агваа
25		Ш.Дарьсүрэн ✓	Тамиржав	Агваа
26		Г.Уранцэцэг	Тамиржав	Агваа
27		П.Түвшинжаргал	Тамиржав	Агваа
Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс				
28	Ахлах мэргэжилтэн	С.Сэржжаргал ✓	Тамиржав	Агваа
29		М.Энхбаяр ✓	Тамиржав	Агваа
30	Мэргэжилтэн	М.Энхболд	Тамиржав	Агваа
31		Я.Одгэрэл ✓	Тамиржав	Агваа
32		Б.Батаа	Тамиржав	Агваа
33		Э.Будханд ✓	Тамиржав	Агваа
34		С.Гончигсумлай	Тамиржав	Агваа
35		Ч.Мөнхбаяр	Тамиржав	Агваа
36		Ч.Хоролгарав	Тамиржав	Агваа
37		М.Уранзул ✓	Тамиржав	Агваа
38		С.Эрдэмсүвд	Тамиржав	Агваа
39		Б.Эрдэнэмөнх	Тамиржав	Агваа

Танилцуулсан:

Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Даваамөнх



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 22-ны
өдөр

Дугаар 393

Улаанбаатар хот

ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 12 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн авто замын ачааллыг зохицуулах зорилгоор замын хөдөлгөөний урсгал, тээврийн хэрэгслийн тоо, байгууллагуудын байршил, тэдгээрийн ажиллагсад, суралцагчдын тоо, түгжрэл ихээр үүсч байгаа зам, цаг хугацаа зэргийг харгалзан нийслэлд байршин үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, яам, Засгийн газрын агентлаг болон тэдгээрийн харьяа байгууллага, бусад төсөвт байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг зохицуулж байх эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улаанбаатар хотод ажил эхлэх цагийг тогтоох тухай" Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 8 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.САЙХАНБИЛЭГ

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.БАЯРЦОГТ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/630

Улаанбаатар хот

Нийслэлийн төр, захиргааны
байгууллагуудын ажлын цагийн
хуваарьт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны "Эрх шилжүүлэх тухай" 393 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн авто замын ачааллыг бууруулах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, амралт чөлөөт цагийг зохицуулах зорилгоор хавсралтад заасан нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 07:00-16:00, 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд 08:00-17:00 цаг байхаар тогтоосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Баярцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай" Нийслэлийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/748 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110203159

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
5 дугаар сарын 17-ний
17630 дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ НИЙСЛЭЛИЙН
ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллага
1	Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба
2	Нийслэл, дүүрэг (хороо)-ийн Засаг даргын Тамгын газар
3	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, харьяа газар
4	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
5	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (хуулийн этгээд, байгууллага)

0502
0



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Няадамчдын зам 1200, Арцэтын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.02.28 № 03/1354

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай” 109 дүгээр тогтоолыг үүгээр хүргүүлж байна.

Иймд Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 тасарч, шинийн 2, 3-ны өдөр Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийж, тогтоолыг дагаж мөрдөн ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АМГАЛАН



1725111217



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 109


Улаанбаатар хот

Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 тасарч, шинийн 2, 3-ны өдөр Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.

2. Ажилтны ажил, амралтын цагийг энэ тогтоолын 1-д заасны дагуу зохицуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын бус төрийн бусад байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

ШТХЗ-ийн дарга Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХ-АМГАЛАН